


Хөдөлмөр, нийгмийн хамгааллын  
яамны Төрийн нарийн бичгийн даргын  
2021 оны 04 дугаар сарын 27-ны өдрийн  
А/39 тоот тушаалын хоёрдугаар хавсралт



ТӨСӨВ

№	Зардлын нэр	Нэгжийн үнэ	Тоо ширхэг	Хэдэн удаа	Нийт үнэ /төгрөгөөр/
1.	"Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх журам"-ын төсөл боловсруулах зөвлөхийн үйлчилгээний зардал /1 хүн ажлын 40 хоног/	85,000	1	40	3.400.000
2.	Төслийг танилцуулах, хэлэлцүүлэгт оролцогчдын цайны зардал	12,000	25	2	600.000
3.	Дүн				4.000.000

- хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх магадлан итгэмжлэлд орж, хариу үйлчилгээг гэрээлэн гүйцэтгэж буй хуулийн этгээдийн төлөөлөлтэй уулзалт хийж, хүүхдэд үзүүлж буй үйлчилгээний үр дүнг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх, төсвийн үр ашигтай байдлын талаар тэдний саналыг сонсох;
- “Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх журам”-ын хэрэгжилт, магадлан итгэмжлэх зөвлөлийн үйл ажиллагаа, магадлан итгэмжлэх, шалгаруулах ажлын явцын бичиг баримтын судалгаа хийх;
- Хууль зүй дотоод хэргийн сайдын 2018 оны А/147 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Захиргааны хэм хэмжээний актын төсөл бэлтгэх явцад нөлөөллийн шинжилгээ хийх аргачлал”-ын дагуу “Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх журам”-ыг шинэчлэн боловсруулж, шинэчилсэн төсөлд нөлөөллийн шинжилгээ хийнэ.

#### **Гүйцэтгэх ажил, үйлчилгээ:**

- “Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх журам”-ыг шинэчлэн боловсруулж, хэлэлцүүлж, саналыг тусган, хэлэлцүүлгийн тэмдэглэл, саналын товъёгийг үйлдэнэ.
- Нөлөөллийн шинжилгээг хийнэ.
- Шинэчилсэн журмыг хэрэгжүүлэх талаар арга зүйн сургалт 1 удаа зохион байгуулна.

#### **Шалгуур үзүүлэлт:**

- Хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр сүүлийн хоёр жилийн хугацаанд судалгаа, шинжилгээ, сургалтын үйл ажиллагаа зохион байгуулсан, хүүхэд хамгааллын чиглэлээр ажиллаж байсан ажлын туршлагатай баг байх.
- Зөвлөхийн боловсрол, эрдмийн зэрэг цол, ажлын туршлага, ажилласан жил, төрийн бус байгууллагын хувьд хийж гүйцэтгэсэн ажлын туршлага зэрэг нь харгалзан үзэх үзүүлэлт болно.

#### **Хяналт, тайлагналт:**


- Зөвлөх нь захиалагчтай байгуулсан гэрээний дагуу ажиллах бөгөөд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн газрын удирдлага, холбогдох мэргэжилтэнтэй байнга холбоотой ажиллана.
- Гэр бүлийн хөгжлийн бодлого зохицуулалтын газар нь ажил гүйцэтгэгчийн гүйцэтгэлийн явц, үйл ажиллагаанд нь саад болохгүйгээр ямар ч үед хяналт тавих эрхтэй.
- Зөвлөх нь ажил гүйцэтгэж буй гүйцэтгэлийн тайлан, төлөвлөгөөний талаар гэрээнд нарийвчлан тусгах бөгөөд ажлын гүйцэтгэлийн тайланг явцын, эцсийн гэсэн 2 удаагийн үр дүнгээр ирүүлнэ.
- Ажлын гүйцэтгэлийн эцсийн тайланг гэрээт ажил дууссанаас хойш 7 хоногийн дотор хүлээлгэн өгнө.

#### **Хугацаа:**

Дээрх ажлыг 2021 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс 06 дугаар сарын 15 -ний өдрийг дуусталх хугацаанд гүйцэтгэнэ.



Хөдөлмөр, нийгмийн хамгааллын  
яамны Төрийн нарийн бичгийн даргын  
2021 оны 4 дугаар сарын 21-ны өдрийн  
А/39 тоот тушаалын нэгдүгээр хавсралт



Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх журмыг шинэчлэн боловсруулж, хэлэлцүүлэх зөвлөхийн ажлын удирдамж

#### **Үндэслэл:**

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хүүхэд бүрийн эрүүл, аюулгүй орчинд өсөж, хүмүүжих, хөгжих, сурч боловсрох, үзэл бодлоо илэрхийлэх, нийгмийн амьдралд оролцох, хамгаалагдах үндсэн эрхийг хангахад чиглэсэн зорилтуудыг дэвшүүлсэн.

2016 оноос Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг баталж, хэрэгжилтийг нь ханган ажиллаж байна. Эдгээр хуулиудыг хэрэгжүүлэх хүрээнд хүчирхийллийн хохирогч болсон хүүхдийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах, эрүүл мэнд, сэтгэл зүй, нийгмийн халамжийн тусламж үйлчилгээ үзүүлэх, гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээ хийх зэрэг хамгааллын үйлчилгээг үзүүлэх харилцааг зохицуулсан журам, стандарт, эрх зүйн баримт бичгүүдийг батлан хэрэгжүүлж байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2016 оны А/330 дугаар тушаалаар баталсан “Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх журам”-ыг хэрэгжүүлэх хүрээнд Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас 2018 онд Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх магадлан итгэмжлэл авсан 19 төрийн бус байгууллагатай, 2019 онд 6 төрийн бус байгууллагатай, 2020 онд 6 төрийн бус байгууллагатай хамтын ажиллагааны гэрээ байгуулж, бэлгийн хүчирхийллийн хохирогч, хараа хяналтгүй хүүхэд, гуйлга гуйдаг хүүхэд, хөдөлмөр эрхэлж байгаа хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хүүхэд болон Түр хамгаалах байраар 2 ба түүнээс дээш удаа үйлчлүүлсэн хүчирхийллийн хохирогч хүүхэд зэрэг 8 бүлгийн 769 хүүхдэд хамгааллын үйлчилгээ үзүүлж хамтран ажилласан байна.

Гэвч зорилтот бүлгийн хүүхдэд үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмжийг үнэлж, дүгнэх, мэргэшсэн төрийн бус байгууллагуудад тавигдах шаардлагыг эрх зүйн шинэчлэл, үйлчилгээний арга зүйтэй уялдуулж авч үзэх, үйлчилгээний төсөв санхүүжилт, хяналтыг тодорхой болгох шаардлагатай байгаа тул Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх журмыг шинэчилж байна.

**Зорилго:** Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх журамд нөлөөллийн шинжилгээ хийж, шинэчлэн сайжруулж боловсруулах

#### **Гүйцэтгэх ажлын хүрээ:**

Зөвлөх нь дараах ажил үүргийг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- Хүүхдийн эрхийн чиглэлээрх Монгол Улсын хууль тогтоомжууд, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, түүний нэмэлт протокол, зөвлөмжүүдийн хэрэгжилт болон хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв, төрийн захиргааны, орон нутгийн байгууллагын стратеги, үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан: